БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА М.БОЛДБААТАР

# АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

| 1 | Хийгдэх ажлын нэр | Бүрдүүлэх баримт, гарах үр дүн |
|---|---|---|
| 2 | Байршил | Наадмын талбай<br>Зочид байрлах гэр хотхон<br>Морь барианы газар |
| 3 | Захиалагч байгууллага | Тайшир сумын ЗДТГазар |
| 4 | | **Тавигдах шаардлага**<br>➢ Ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир усны шугам хоолойн байрлал болон угсралт нь БНБД 40-06-15 “Дотор сантехникийн систем”-ийн шаардлагад нийцсэн байна.<br>➢ Бие засах суултуурын өрөө, гар угаах өрөөний ханыг /доторлогоог/ ус чийгэнд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байна.<br>➢ Дотор талын ус, цахилгааны шугамыг далд хийцээр хийнэ.<br>➢ Ус зайлуулах хоолойн гарах, шугам хоолойг PVC материалаар хийнэ.<br>➢ Цэвэр бохирыг бүрэн шийдвэрлэх<br>➢ Хаалганы цоож, бат бэх, гадна, дотроосоо онгойдог байх<br>➢ Ариун цврийн байгууламжийн барилгын гадна талын хаягийг босоо хэлбэрээр, нүдэнд шууд харагдах газар угсарч байрлуулна.<br>➢ Суултуурын тусгаарлах хаалт нь бат бэх, ус чийг, ялзрал элэгдлийн хамгаалалттай, цэвэрлэхэд хялбар, материалаар хийгдсэн байна. Өргөн нь 0.45м, өндөр нь 0.8м-ээс багагүй байна. Тусгаарлах хавтанд тавиур, тавцан угсрах, тодорхой даац авах боломжтой байна.<br>➢ Эрэгтэй, эмэгтэй тусдаа ариун цэврийн өрөөний гар угаах угаалтуурын тоог MNS 6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” /4.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага /MNS 4236:2003/-ын дагуу төлөвлөнө.<br>**Ажлын тоо хэмжээ**<br>Нийтийн бие засах боловсон жорлон нь дотор хэсэгт техникийн өрөө болон бие засах өрөө буюу үндсэн байгууламж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. /тасалгаатай/<br>**Байгууламжийн гадна хэсэг:**<br>Сууж бие засах зориулалттай байгууламж нь өвлийн улиралд ашиглаж болохуйц дулаалга, доторлогоотой /хана, тааз, шал гэх мэт/ урт 6м, өргөн 2.4м-ээс багагүй хэмжээтэй тохижуулсан 20 тн-ын контейнер байна. Контейнерын гадаргуу ус, чийгэнд тэсвэртэй төмрийн зориулалтын будгаар будсан байх бөгөөд цагаан саарал өнгөтэй, хүрээг нь цагаан өнгөөр будна.<br>**Цонх:** Битүүмжлэл сайтай 0.5мх0.8м хэмжээтэй вакум |

| | | |
|---|---|---|
| | | цонх 2 ширхэг<br>Хаалга: Дулаалгатай, бат бөх, 0.96мх2.05м хэмжээтэй хаалга байна.<br>**Шал:** Хөөсөн хавтангаар дулаалж, модон шалтай /захиалагчтай зөвшилцөх/ байна.<br>**Дотор хэсэг**:<br>Байгууламжийн дотор зохион байгуулалт нь техникийн болон бие засах өрөө буюу үндсэн байгууламж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.<br>1. Бие засах буюу үндсэн байгууламж хэсэгт дараах бүрдэл орно. Үүнд:<br>1.1 Суултуур болон түүний дагалдах тоног төхөөрөмж нь бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй байх бөгөөд 4 суултуур /эрэгтэй, эмэгтэй/ байна.<br>1.2 Байгууламж дотроо 4 тасалгаатай байх бөгөөд тасалгааг бат бэх хавтангаар хийж, бие засах өрөөний хаалганы нээгдэх хэмжээ 0.6мх2м кабин хэмжээ нь 0.85мх1.50м-ээс багагүй байна.<br>2. Техникийн өрөө<br>2.1 Нөөцийн зориулалтын сав 1 тн багтаамжтай байх<br>2.2 Халуун, хүйтэн усны 80вт-ын бойлор байрлуулах<br>2.3 Сантехникийн шугам хоолойг PVC материалаар хийнэ.<br>2.4 Насос суурилуулах /550 вт-аас багагүй/<br>**Нэмэлт тоноглол:**<br>1. Угаалтуур 2 ширхэг<br>2. Розетка 4 ширхэг /техникийн өрөөнд-1, бусад-3/<br>3. Бүх цахилгаан холболтыг бүрэн шийдэх<br>4. Унтраалга 3 ш /техникийн өрөөнд-1, бусад-3/<br>5. Гэрэл 4 ширхэг / техникийн өрөөнд-1, бусад-3/<br>6. Цаас болон саван тогтоогч тус бүр 2 ширхэг<br>7. Толь-2 ширхэг<br>**Бохир шингээх хэсэг:**<br>1. Бохир шингээх хэсгийг байгууламжаас тусдаа нүхэн байдлаар шийдэх<br>2. Нүхэн шингээгч нь бохир задлах ашигт бактеритай байх |
| 5 | Хийж хүлээлгэн өгөх хугацаа | Тус ажлыг 7 сарын 1-ны дотор хийж дуусган, хүлээлгэн өгнө. |
| 6 | Багцын ажлын үнэ | 3 ширхэг бие засах байгууламж хийх |
| 7 | Гүйцэтгэгч байгууллагад тавих шаардлага | • Чанартай хийж гүйцэтгэн 1 сарын дотор багтаан нийлүүлэх<br>• Баталгаа 1 жил байх бөгөөд гүйцэтгэгч эвдрэл гэмтлийг өөрийн хөрөнгөөр засварлах<br>• Ижил төстэй ажил хийж байсан туршлагатай байх |